



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (364)

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай*
- *Хэлэлцээр батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот**

**2004 он**



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны наймдугаар сарын 9

№31 (364)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

333.	Журам батлах тухай	Дугаар 112	671
334.	Хурдан морины шигшмэл, бүсийн уралдааныг зохион байгуулах тухай	Дугаар 128	672
335.	Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 143	672
336.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 146	676

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5 –ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

#### Журам батлах тухай

дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Төрийн албаны тухай хуулийн 30.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 218 дугаар тогтоолын 2

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Ө.ЭНХТҮВШИН

*Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолын хавсралт*

### ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ТУСЛАМЖ ОЛГОХ НӨХЦӨЛ, ЖУРАМ

1. Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан тусламж олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Төрийн албаны тухай хуулийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байсан байгууллага нь олгоно.

3. Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн захиргааны албан хаагчид 6 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн байгууллага олгоно.

Дээр дурдсанаас бусад шалтгаанаар төрийн албанаас чөлөөлөгдсөн, өөрийн хүсэлтээр төрийн албанаас гарсан, эсхүл төрийн байгууллага хооронд

шилжин ажилласан тохиолдолд энэ зүйлд заасан тусламжийг олгохгүй.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь түүний 3 жилийн албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг төрийн тухайн байгууллага олгоно.

5. Төрийн албан хаагчид дараахь тохиолдолд ажиллаж байгаа байгууллагаас нь тусламж олгож болно:

а/албан хаагчийн өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжихэд зориулан тухайн албан хаагчийн 1 сарын албан тушаалын цалингаас нь хэтрүүлэхгүйгээр жилд нэг удаа буцалтгүй тусламж;



б/ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр (нөхөр)-ийн төрсөн нутагт явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг автомашин, төмөр замын тээврийн тухайн үед мөрдөж байгаа энгийн үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа;

в/албан хаагчийн гэр бүлийн гишүүн, төрөл садан (эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх)-гийн хүн нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ тэтгэхэд нь мөнгөн болон эд материалын тусламж.

6. Энэ журмын 5 дугаар заалтад заасан тусламжийн хэмжээ, түүнийг олгохтой холбоотой харилцааг байгууллагын дотоод журам, хамтын гэрээ, хэлэлцээр болон холбогдох бусад эрх зүйн актаар зохицуулна.

7. Төрийн албан хаагчид хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчиж тусламж олгосноос улс, байгууллагад учирсан хохирлыг тухайн тусламжийг олгох шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан хариуцна.

8. Энэхүү журамд заасан тусламжид шаардагдах хөрөнгийг урьдчилан тооцож тухайн жилийн төсөвт тусгана.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Хурдан морины шигшмэл, бүсийн уралдааныг зохион байгуулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

зохион байгуулахыг Биеийн тамир, спортын улсын хороо (Г.ПҮРЭВ-ОЧИР)-нд зөвшөөрсүгэй.

Хурдан морины бүсийн уралдааныг төв, баруун, зүүн, хангай, говийн бүсүүдэд 3 жилд нэг удаа, бүсийн уралдаанаас шалгарсан морьдыг оролцуулсан шигшмэл уралдааныг 3 жилд нэг удаа төвийн бүсэд холбогдох байгууллагууд, тухайн аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

П.НЯМДАВАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

Бизнесийг дэмжих, бизнес эрхлэхэд тулгарч байгаа хүнд суртлыг багасгах талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтыг хэрэгжүүлэх, Засгийн газар, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

эрхлэгчдэд сурталчлах арга хэмжээ авахыг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /С.ДЭМБЭРЭЛ/-д зөвлөмж болгосугай.

1. Монголын бизнес эрхлэгчдийн их чуулганы зөвлөмж, бизнес эрхлэгчдээс гаргасан саналыг харгалзан Засгийн газраас хэрэгжүүлэх "Бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаархи арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

3. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал болон цаашид бизнес эрхлэхтэй холбоотой асуудлаар шинээр боловсруулах хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн төслийг Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороотой зөвшилцсөний үндсэн дээр боловсруулан Засгийн газарт оруулах, баталж мөрдүүлж байхыг холбогдох сайд, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороогоор хэлэлцүүлэн гарсан санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин нарт тус тус даалгаж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний чиглэл бүрээр хамтран ажиллаж, гарсан шийдвэр, санал, дүгнэлтийг бизнес

4. Бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, бизнес эрхлэгчдэд үйлчлэх шат дамжлагын тоог цөөрүүлж хүнд суртлыг багасгах, бизнес эрхлэхтэй холбогдсон тусгай зөвшөөрлийг цөөрүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжид нийцээгүй тусгай зөвшөөрөл, лиценз, төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авч дүнг Засгийн газарт танилцуулж, Монголын үндэсний худалдаа,



аж үйлдвэрийн танхимд мэдээлэхийг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээг 2004 оны 9 дүгээр сарын 1-ний дотор "Нэг цэгийн үйлчилгээ"-ний зарчимд шилжүүлэхийг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

6. Бизнес эрхлэгчдийн саналыг төрийн бодлогод тусгуулах, төр, засгийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тухайн нутаг дэвсгэрийнхээ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын салбартай хамтран ажиллах механизмыг 2004 оны 9 дүгээр сарын 1-ний дотор бий болгон ажиллуулахыг Засаг дарга нарт даалгаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

7. Монгол Улс "Олон улсын бараа, бүтээгдэхүүнийг кодлох Европын байгууллага"-д элссэнтэй холбогдуулан бараа, бүтээгдэхүүний "Зураасан код" хэрэглэх үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг холбогдох сайд нарт даалгасугай.

8. Засгийн газар, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, харилцан ойлголцох механизмыг төгөлдөржүүлэх, жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор дараахь арга хэмжээг судлан 2004-2005 онд хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хорооны Засгийн газрын хэсгийн дарга, Санхүү эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай:

а/орон нутагт эдийн засаг, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хөдөөгийн бизнес эрхлэгчдийн

үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэн хөгжүүлэх талаар авах цогц арга хэмжээний талаархи тодорхой саналыг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран боловсруулж Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороогоор хэлэлцүүлэх;

б/Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас зах зээлийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, монголын аж ахуйн нэгжүүдийн олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах талаар гаргаж байгаа санаачилгыг дэмжих, хамтран ажиллах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах;

в/бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шинээр хууль тогтоомж гаргахын өмнө Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороогоор хэлэлцдэг байх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хамтран ажилладаг байх журам тогтоох;

г/худалдаа, бизнесийг дэмжих, бизнесийн үйл явц, худалдаа эрхлэхэд учирдаг төрөл бүрийн хориг саадыг хөнгөвчлөх, электрон худалдааг хөгжүүлэх зорилгоор Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хорооны дэргэд Худалдаа, бизнесийг хөнгөвчлөх зөвлөлийг байгуулж ажиллуулах.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

**Засгийн газрын 2004 оны 143 дугаар  
тогтоолын хавсралт**

## БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ТАЛААРХИ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах ЭЗЭН
1	Бизнес, гадаад худалдааг хөнгөвчлөх олон улсын практикийг нэвтрүүлэх. Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн гаалийн байгууллагаас энэ чиглэлээр гаргасан зөвлөмж, чиглэлийг гаалийн үйл ажиллагаанд эрчимтэй нэвтрүүлэх. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, мэргэжлийн холбоодтой идэвхтэй хамтран ажиллах талаар тодорхой арга хэмжээ авах	2004 оны 9 дүгээр сарын 1	СЭЭЯ, МҮХАҮТ

2	Импортын барааны гаалийн хэлцлийн үнэ, жишиг үнийн мэдээллийн баазыг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран улирал бүр шинэчилж байх, жишиг үнийг тухай бүр тогтооход субъектив нөлөө орж буйг зогсоох, жишиг үнийг ил тод нийтэд мэдээлж байх, "нээлттэй гааль" веб хуудсыг тогтмол ажиллуулдаг болох	2004 оны 9 дүгээр сарын 1	УГЕГ, МҮХАҮТ
3	Гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, баримт бичгийг ижилтгэх чиглэлээр удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ авах, малын гаралтай түүхий эдийг зөвхөн мал эмнэлгийн сертификатыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийж байхаар зохион байгуулах	2004 оны 9 дүгээр сарын 1	УГЕГ, УМХГ
4	Гаалийн бичиг баримтыг хялбарчлах, электрон хэлбэрт шилжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа гаалийн мэдээллийн автоматжуулсан системийг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх	2004 оны 9 дүгээр сарын 1	УГЕГ
5	Дэлхийн худалдааны байгууллага болон бусад олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд импортыг үр ашигтай орлох бүтээгдэхүүний судалгаа гарган түүний үндсэн дээр импортын барааны тарифыг ялгавартай тогтоох асуудлаар санал боловсруулах	2004 оны 9 дүгээр сарын 1	СЭЗЯ, ҮХЯ, Гаалийн тарифын зөвлөл
6	Засгийн газрын 2002 оны 108 дугаар тогтоолтой Үйлдвэр, худалдааны сайд, Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалын холбогдох заалтуудыг уялдуулан боловсронгуй болгох	2004 оны 7 дугаар сарын 1	ҮХЯ, УМХГ
7	Гаалийн байгууллага үйл ажиллагаандаа холбогдох дүрэм журмыг хатуу баримтлан ажиллах, гаалийн улсын байцаагч нарын хариуцлагыг өндөржүүлэх, тэдэнтэй холбогдон гарсан мэдээллийг шуурхай шийдвэрлэдэг болох	2004 оны сүүлийн хагаст	УГЕГ
8	Түр болон байнгын боомтуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ авч олон нийтэд ил тод мэдээлэх	2004 оны 9 дүгээр сарын 1	УГЕГ
9	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран татварын ачаалал, татварын хувь хэмжээ, татвар хураамжийн механизмын талаар санал боловсруулах, татвар төлөгчид нь татварыг нийтээрээ бүрэн төлдөг болгох зохион байгуулалтын арга хэмжээ авах	2004 оны 9 дүгээр сарын 1	СЭЗЯ, МҮХАҮТ
10	Махыг экспортод гаргахад олгодог Мал эмнэлгийн сертификат авахад хураамж авч байгааг хянаж 1 кг тутмын үнэлгээг бууруулах боломжийг судлах	2004 оны 8 дугаар сарын 1	УМХГ
11	Улсын мэргэжлийн хяналтын газар болон түүний харьяа албадаас аж ахуйн нэгжүүд дээр очдог шалгалтуудыг нэгтгэн зохион байгуулж, аль нэг шатны байгууллагаас хийсэн шалгалтын дүнг бусад нь хүлээн зөвшөөрдөг системтэй болгох арга хэмжээ авах	2004 оны 8 дугаар сарын 1	УМХГ
12	Аж ахуйн нэгжийг мэргэжлийн хяналтын албанаас шалгах үйл ажиллагааг боловсронгуй, шуурхай болгох	2004 оны 9 дүгээр сарын 1	УМХГ, бүх шатны Засаг дарга
13	Улс орны эдийн засгийн онцлог, үйлдвэрлэлийн салбаруудын өрсөлдөх чадвар, экспортыг дэмжих, импортыг үр ашигтай орлох, импорттой өрсөлдөх бодлогыг хэрэгжүүлэх зорилтуудыг харгалзан хөнгөлөлтийг ялгавартай үзүүлэх зарчим, чиглэлийг баримтлан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж санал боловсруулах	2004 оны 9 дүгээр сарын 1	ҮХЯ, СЭЗЯ, ГХГХОГ, УГЕГ
14	Дотоодын хөрөнгө оруулагчдад зохих хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах	2004 оны 9 дүгээр сарын 1	ҮХЯ, СЭЗЯ



15	Тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд даатгуулагчдын нэрийн данс, түүний ашиглалт, зарцуулалтын талаар авах арга хэмжээний талаар санхүү боловсруулах	2004 оны П хагас	НХХЯ
16	Тэтгэврийн даатгалын санд ажил олгогчдын төлөх шимтгэлийг бууруулах, ажилчдын тоогоор босго тогтоож шимтгэлийн хувь хэмжээнд хөнгөлөлт үзүүлэх талаар судалж санал боловсруулах	2004 оны 9 дүгээр сарын 1	НХХЯ, МУХАУТ
17	Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг дундаж цалингийн 70 хувиар тооцдог байсныг өөрчилж, 6 сараас дээш шимтгэл төлсөн бол дундаж цалингийн 100 хувиар тооцож тэтгэмж олгодог болох асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, эрхийн актад тусгах санал боловсруулах	2004 оны П хагас	НХХЯ
18	Монгол Улсад стандартын ажлыг зохион байгуулж байгаа бүтэц-зохион байгуулалтын хэлбэр, стандарт боловсруулах, хэрэгжүүлэх одоогийн механизмыг өөрчлөн дэлхий нийтийн хандлага, олон улсын стандартын байгууллагын бодлого, зөвлөмжийн дагуу зайлшгүй стандарт давамгайлсан тогтолцооноос сайн дурын стандарт давамгайлсан тогтолцоонд шилжих бэлтгэл хангах арга хэмжээ авч эхлэх	2004 оны 9 дүгээр сарын 1	ҮХЯ, МУХАУТ
19	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран судалж тохирлын гэрчилгээ, үндэсний тохирлын тэмдэг олгох асуудлаар гарсан эрхийн актуудыг боловсронгуй болгон өөрчлөх талаар санал боловсруулах	2004 оны 8 дугаар сарын 1	ҮХЯ
20	Нэн түрүүнд өөрчлөх шаардлагатай үндэсний стандартын жагсаалт гаргаж бизнес эрхлэгчдийн саналыг авч өөрчлөх арга хэмжээ авах	2004 оны 8 дугаар сарын 1	СХЗТ
21	Итгэмжлэгдсэн аль ч лабораторид барааг шинжлүүлж, тэдгээрийн шинжилгээний дүгнэлтийг бүх байгууллага хүлээн зөвшөөрдөг болгох чиглэлээр тодорхой шийдвэр гаргах, түүнийг бизнес эрхлэгчдэд сурталчлах	2004 оны 8 дугаар сарын 1	СХЗТ, УМХГ, УГЕГ
22	Төлөөлөгчийн газрууд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа байдалд тогтмол хяналт тавьж, авсан арга хэмжээнийхээ талаар олон нийтэд мэдээлдэг болох	2004 оны 9 дүгээр сарын 1	ҮХЯ, холбогдох яам
23	Төрийн байгууллагуудын зарим чиг үүргийг холбогдох төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар санал боловсруулах	2004 оны 9 дүгээр сарын 1	холбогдох яам
24	Венч капитал, бизнес инкубаторыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар судалгаа хийж, төсөл боловсруулах	2004 оны 11 дүгээр сарын 1	ҮХЯ
25	Судалгаа, шинжилгээний ажлын шинжлэх ухааны үндэслэл, үр өгөөжийг эрс дээшлүүлэх, улсын төсөв болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас энэ зорилгоор олгож байгаа хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор шинжлэх ухаан, бизнесийн холбоог бэхжүүлэх талаар санал боловсруулах	2004 оны 11 дүгээр сарын 1	БСШУЯ, ШУА, МУХАУТ
26	Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага хийсэн шинжилгээ судалгаа, гаргасан шинэ технологио борлуулан санхүүждэг системтэй болгох талаар холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэх асуудлыг судлах	2004 оны 11 дүгээр сарын 1	БСШУЯ
27	Мэргэжлийн сургалтыг бизнесийн практиктай уялдуулах талаар Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран санал боловсруулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	2004 оны 11 дүгээр сарын 1	БСШУЯ, МУХАУТ
28	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах	2004 оны 11 дүгээр сарын 1	СЭЗЯ, холбогдох яамд



29	Олон улсын байгууллагууд хандивлагч орнуудаас хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихэд зориулан арилжааны банкуудаар дамжуулан олгож буй хөнгөлөлтэй зээлийн олголтын өнөөгийн механизмыг дан ганц хөрөнгийн барьцаа бус, зээлийн зэрэглэл, баталгаа, даатгалын зарчим дээр үндэслэдэг болох шинэ механизмыг судлан боловсруулах	2004 оны 10 дугаар сарын 1	СЭЗЯ, Монгол банк, МҮХАҮТ
30	Олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас хувийн хэвшилд зориулан олгох зээлийг хуваарилах механизмыг боловсронгуй болгох санал боловсруулах	2004 оны 10 дугаар сарын 1	СЭЗЯ, Монгол банк, МҮХАҮТ
31	Эрх бүхий байгууллагаас иргэд, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх явцад хяналт тавих, иргэд, аж ахуйн нэгжүүдээс энэ асуудлаар гаргасан гомдол санал, байгаль орчинд халгүй цэвэр үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр хэлэлцэж санал гаргах Газар, байгаль орчны дэд хороог Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хорооны дэргэд байгуулж ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэх	2004 оны 10 дугаар сарын 1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, МҮХАҮТ
32	"Нээлттэй нийслэл" веб хуудас тогтмол ажиллуулж газар олголт, хяналт шалгалт зэрэг асуудлаар нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын тухайн 7 хоногийн үйл ажиллагаа, хэнд, хэдэн зөвшөөрөл олгосон, татгалзсан бол ямар үндэслэлээр татгалзсан талаар тодорхой мэдээллүүдийг байнга мэдээлэх	2004 оны 9 дүгээр сарын 1	Нийслэл, дүүргийн Засаг дарга
33	Дүүргийн газрын харилцааны асуудал эрхэлсэн албадаас тухайн 7 хоногт газрын зөвшөөрөл олгосон байгууллага, хувь хүмүүсийн тоог интернет, дотоод мэдээллийн самбараар мэдээлэх, тогтмол шинэчилж байх	2004 оны 9 дүгээр сарын 1	Бүх шатны Засаг дарга
34	Нийслэлийн Захирагчийн ажлын алба, дүүргийн холбогдох байгууллагаас аж ахуйн нэгжүүд дээр очдог шалгалтыг мэргэжлийн хяналтын болон татварын байгууллагын шалгалттай уялдуулан зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудаас төрөл бүрийн хандив авдгийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтантай хариуцлага тооцдог болох	2004 оны 8 дугаар сарын 1	Нийслэлийн захирагчийн ажлын алба, дүүрэг, УТЕГ, УМХГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-йг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ГОГТООХ нь:

ажиллагааны тухай Хэлэлцээрийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газрын хооронд байгуулсан Эдийн засаг, техникийн хамтын

**САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

☎ 329487

☎ 329612

Индекс 14033

Хэвлэлийн хуудас 1